**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/528 Хэрлэн сум

Үнэ бууруулж, худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээ”-ний 2 дугаар зүйлийн 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн өмчит 2 байгууллагын 162,413,100 төгрөгийн балансын үнэтэй 15,000,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 147,413,100 төгрөгийн үлдэх өртөгтэй 2 нэр төрлийн эд хөрөнгийг анхны дуудлага худалдааны үнээс тус тус 20 хувиар үнэ бууруулан худалдахыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн өмчит 1 байгууллагын 27,900,000 төгрөгийн балансын үнэтэй, 15,840,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 13,860,000 төгрөгийн үлдэх өртөгтэй автомашиныг дуудлага худалдаагаар худалдахыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.“Эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Г.Лхагвахатан | Орон нутгийн өмчийн газрын дарга |
| Хөтлөгч: | Ш.Цамбасүрэн | Орон нутгийн өмчийн газрын Өмчийн мэргэжилтэн |
| Тэмдэглэл хөтлөгч: | Л.Отгончимэг | Орон нутгийн өмчийн газрын хуулийн зөвлөх |

D:\My Document Захирамж-2022

231011 387

4.Эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2022 оны 10 дугаар сарын 28-ны 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 тоотод зохион байгуулсугай.

5.Эд хөрөнгийг худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын
2022 оны 10 дугаар сарын 14-ний
А/528 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Үнэ бууруулан худалдах хөрөнгийн жагсаалт

| Эзэмшигч байгууллагын нэр | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | байгууллагын үнийн санал | Орон нутгийн өмчийн газрын санал | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар | Toyota crown 8500 ХЭА | 2014 | 15,000,000 | 15,000,000 | 0 | 3,000,000 | 2,400,000 | 2,400,000 |
| "Нийтлэг үйлчилгээ" Орон нутгийн өмчийн газар | Баян-Эрдэсийн байр (1 дүгээр давхар) | 2002 | 147,413,100 | 0 | 147,413,100 | 250,000,000 | 200,000,000 | 200,000,000 |
| Нийт дүн | | | 162,413,100 | 15,000,000 | 147,413,100 | 253,000,000 | 202,400,000 | 202,400,000 |

Аймгийн Засаг даргын
2022 оны 12 дугаар сарын 14-ний
A/528 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт

| д/д | Эзэмшигч байгууллагын нэр | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Байгууллагын үнийн санал | Орон нутгийн өмчийн газрын санал | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Батширээт сумын Эрүүл мэндийн төв | УАЗ-22069 | 2018 | 27,900,000 | 15,840,000 | 13,860,000 | 2,000,000 | 2,000,000 | 4,000,000 |